Монгол Улсын Их Хурлын Хууль зүйн
байнгын хорооны 2020 оны .... дугаар
тогтоолын хоёрдугаар хавсралт

# НЭР ДЭВШИХ ТУХАЙ ХҮСЭЛТ ГАРГАГЧИЙН АНКЕТ

| Д/д | Шалгуур үзүүлэлт | Мэдээлэл |
|---|---|---|
| 1 | **Нэр**<br>Овог, эцэг, эхийн нэр, өөрийн нэр, нэрээ өөрчилж байсан бол өмнө нь хэрэглэж байсан нэр | Ганбатын НАРАНТУЯА |
| 2 | **Хүсэлт гаргагчийн хаяг**<br>Иргэний үнэмлэхэд байгаа хаяг | |
| 3 | **Төрсөн огноо**<br>Төрсөн газар | |
| 4 | **Боловсрол**<br>Дээд боловсрол эзэмшсэн сургууль тус бүрийг сүүлд төгссөн сургуулиас нь эхлэн жагсаан бичнэ. Сургууль тус бүрд суралцсан хугацаа, авсан зэрэг, огноог бичнэ. | • 2012 – 2017 Австралийн Үндэсний Их Сургуульд олон улсын нийтийн зүй, хүний эрхийн гэрээний хэрэгжилтийн асуудлаар докторын (PhD) зэрэг хамгаалсан. Австралийн Үндэсний Их Сургуулийн төгсөлтийн хувиараас шалтгаалан 2018 онд дипломоо гаргаж авсан.<br>• 2008 – 2010 Мельбурны Их Сургуульд хууль зүйн мастер (LL.M) зэрэг хамгаалсан.<br>• 1998 – 2003 Монгол Улсын Их Сургуулийн Хууль зүйн сургуульд суралцаж, эрх зүйч мэргэжил эзэмшсэн.<br>• 1999 – 2002 Монгол Улсын Их Сургуулийн Гадаад хэл, соёлын сургуулийн дипломын хөтөлбөрт хамрагдаж, Хятад хэлний орчуулагч мэргэжил эзэмшсэн. |
| 5 | **Ажил эрхлэлт**<br>Их, дээд сургууль төгссөнөөс хойш ажилласан төрийн байгууллага, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллага болон бусад байгууллагыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн жагсаан бичнэ. Ажил олгогчийн нэр, хаяг, утас, цахим хуудас болон ажлын байрны нэрийг бичнэ. | • 2018.8 сараас – өнөөг хүртэл **бие даасан шинжээчээ**р ажиллаж байна. Дараах 3 үндсэн чиглэлээр ажилладаг. (1) Австралийн Үндэсний Их Сургуулийн Нийгмийн Зохицуулалт, Дэлхийн засаглалын сургууль (http://regnet.anu.edu.au/our-people/visitors/nara-ganbat) болон Монголын Хүрээлэнгийн зочин судлаачаар (http://mongoliainstitute.anu.edu.au/people/research-affiliates/narantuya-ganbat) ажиллаж, докторын судалгаандаа суурилсан эрдэм шинжилгээний нэг сэдэвт бүтээл туурвиж байна. Австралийн Үндэсний Их Сургууль, Галвэй дэх Ирландын Их Сургуулийн бакалавр, мастерын хөтөлбөрт НҮБ-ын хүний эрхийн гэрээ конвенциос үүдэлтэй нийгмийн өөрчлөлтийн талаар бакалавр, мастерын хөтөлбөрт зочин лектороор оролцдог. (2) Олон улсын байгууллага, төсөл, хөтөлбөрүүдэд зөвлөхөөр ажилладаг. Тухайлбал, одоогоор ХБНГУ-ын Фрайбург хотод төвтэй Particip GmBH |

| | | |
|---|---|---|
| | | (https://www.particip.de) олон улсын зөвлөх үйлчилгээний фирмд хүний эрхийн гэрээний хэрэгжилтийн асуудлаарх шинжээчээр ажиллаж, НҮБ-ын хүний эрхийн 7 гэрээ конвенцийг Ази тивийн 11 улс хэрэгжүүлж буй байдалд дүн шинжилгээ хийж байна. Үүний хамт Олон Улсын Хөгжлийн Эрх зүйн Байгууллагын Монгол дахь суурин төлөөлөгчийн газрын (https://www.idlo.int/where-we-work/asia/mongolia) "Гэр бүлийн хүчирхийллийн хэрэг, зөрчлийг шалган шийдвэрлэхтэй холбоотой Монгол Улсын хууль тогтоомж, тэдгээрийн хэрэгжилтийг хохирогч төвтэй хандлагын үүднээс үнэлэх нь" сэдэвт судалгааны үндэсний ахлах зөвлөхөөр ажиллаж байна. Өмнө нь зөвлөх үйлчилгээний хүрээнд НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр, Швед Улсын Лундын Их Сургуулийн Хүний эрх, хүмүүлэгийн эрх зүйн Раул Валленбергийн хүрээлэн, Ази, Номхон далайн Хүний эрхийн Үндэсний байгууллагуудын Форум, Нээлттэй нийгэм форум ТББ зэрэг байгууллагуудад зөвлөхөөр ажиллаж байсан. Олон улсын шинжтэй эдгээр ажлуудыг одоогоор Улаанбаатарт төвтэй гүйцэтгэж байна. (3) Монгол Улсын нийгэм, улс төр, эрх зүйн асуудлаар бичсэн нийтлэлээ www.jargaldefacto.com болон өөрийн ww.gnarantuya.com цахим хуудсуудаар түгээдэг.<br><br>• 2012.02 – 2017.06 Австралийн Үндэсний Их Сургуулийн **докторант судлаач.** Энэ хугацаанд тус их сургуулийн Олон Улсын Засаглал, Шударга ёсны төв (Centre for International Governance and Justice)-д Австралийн Судалгааны Зөвлөлийн санхүүжилттэй "Хүний эрхийг хамгаалах олон улсын тогтолцоог бэхжүүлэх нь: Эрх, зохицуулалт, зан үйл" (Strengthening the International Human Rights System: Rights, Regulation and Ritualism) эрдэм шинжилгээний төсөлд судлаачаар ажилласан. Төвийн болон төслийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг эндээс үзнэ үү: (http://regnet.anu.edu.au/research/centres/centre-international-governance-and-justice-cigj).<br><br>• 2011.01 – 2012.01 Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисст **Ажлын албаны дарга**<br><br>• 2007.03 – 2011.01 Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисст **бодлого, дүн шинжилгээ хариуцсан ахлах референт**<br><br>• 2004.02 – 2007.03 Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисст **бодлого дүн шинжилгээ хариуцсан референт**<br><br>• 2003.09 – 2004.02 Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Газрын тосны хэрэг эрхлэх газарт **олон улсын гэрээ, хэлэлцээр хариуцсан мэргэжилтэн** |
| **6** | **Нэр дэвших тухай хүсэлт гаргасан албан тушаал**<br>Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн эсхүл Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал | Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүнд нэрээ дэвшүүлж байна. |

| | | |
|---|---|---|
| | эрхэлсэн гишүүний алинд нэр дэвшиж байгаа талаар бичнэ. | |
| **7** | **Эрх зүйч мэргэжлээр эрхэлсэн ажил**<br>Хүсэлт гаргагч эрх зүйч мэргэжлээр сүүлийн арваас доошгүй жил эрхэлсэн ажлыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дараалалаар бичиж, тодорхойлно. Үүнд дараах мэдээллийг бичнэ.<br>-албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа;<br>-ажлын байрны тодорхойлолт;<br>-удирдах албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл;<br>-хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан таваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл. | 2003 оны 9 сарын 1-нээс эхлэн 17 жил эрх зүйчээр ажиллаж байна. 5 дахь хэсэгт жагсаасан бүх ажлууд хүний эрхийн асуудал, хууль тогтоомж, олон улсын гэрээтэй холбоотой.<br><br>2018 оны 8 дугаар сараас өнөөг хүртэл **бие даасан шинжээч** (5 дахь хэсгийн тайлбарыг үзнэ үү).<br><br>• 2018 оны 8 сараас өнөөг хүртэл. Австралийн Үндэсний Их Сургуулийн Нийгмийн Зохицуулалт, Дэлхийн засаглалын сургууль (The School of Regulation and Global Governance)-ийн зочин судлаач. Захирал Professor Kathryn Henne (Цахим шуудан: kathryn.henne@anu.edu.au; Утас: +61 2 6125 1255; Хаяг: Room: 2.08, Coombs Extension building #8, Australian National University, Canberra, Australia);<br>   ○ Докторын судалгаанд ажилд үндэслэсэн эрдэм шинжилгээний өгүүлэл, нэг сэдэвт бүтээл бичих, хэвлүүлэх;<br>   ○ Эрдэм шинжилгээний төсөл боловсруулах, талуудтай хамтарч ажиллах;<br>   ○ Сургалт, эрдэм шинжилгээний бусад ажилд оролцох;<br><br>• 2019 оны 8 сараас өнөөг хүртэл. Particip GmBH зөвлөх үйлчилгээний фирм, Европын холбооны Хүний эрхийн бодлогыг дэмжих төсөл (EU Human Rights Policy Support Project)-ийн хүний эрхийн шинжээч (key human rights expert), Судалгааны багийн ахлагч Dr. Adam Novak (Цахим шуудан: adam.novak@particip.com; Утас: +421 904 232 129; Хаяг: Merzhauser Str.183, D - 79100 Freiburg, Germany);<br>   ○ Армен, Болив, Бангладеш, Киргизстан, Узбекстан, Тажикстан, Пакистан, Монгол, Филиппин, Шри Ланка зэрэг 13 улсыг хамарсан судалгааны аргачлал боловсруулахад оролцох.<br>   ○ НҮБ-ын хүний эрхийн 7 гэрээг Монгол Улс хэрэгжүүлж байгаа байдалд 2019-2020 онд 3 удаагийн дүн шинжилгээ хийх, тайлан боловсруулах, хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтийг сайжруулах зөвлөмж өгөх.<br>   ○ Дүн шинжилгээний үр дүнд тулгуурлан Европын Комисст танилцуулах үндсэн асуудлуудыг боловсруулах.<br><br>• 2020 оны 1 сараас 2020 оны 4 сарыг хүртэл. Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллагын Монгол дахь суурин төлөөлөгчийн газарт судалгааны үндэсний ахлах зөвлөх. Суурин зохицуулагч Ms Tara Neal (Цахим шуудан: Tneal@idlo.int; Утас: 320904; Хаяг: Чингэлтэй дүүрэг, Жигжиджавын гудамж 3, Бодь цамхагийн 603 тоот);<br>   ○ Олон улсын зөвлөхтэй хамтран “Гэр бүлийн хүчирхийллийн хэрэг, зөрчлийг шалган шийдвэрлэхтэй холбоотой Монгол Улсын хууль тогтоомж, тэдгээрийн хэрэгжилтийг хохирогч төвтэй хандлагын үүднээс үнэлэх нь” нийгэм-эрх зүйн судалгааны |

| | | |
|---|---|---|
| | | аргачлал боловсруулах.<br>○ Үндэсний ахлах судлаачийн хувиар 4 судлаачийг удирдлага, арга зүйгээр хангах, судалгааны ажлыг явуулах.<br><br>• 2012 оны 2 сараас 2017 оны 7 сарыг хүртэл Австралийн Үндэсний Их Сургуулийн докторант судлаач<br><br>○ “Хүний эрхийг хамгаалах олон улсын тогтолцоог бэхжүүлэх нь: Эрх, зохицуулалт, зан үйл” төслийн хүрээнд Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенци хэрэгжиж эхлэснээс хойш 10 жилийн дотор Австрали, Монгол улсуудын эрх зүй, улс төр, нийгэмд үзүүлсэн нөлөөллийг судлаж, эрдэм шинжилгээний бүтээл боловсруулах.<br>○ Энэ хүрээнд хоёр улсын улс төрчид, дипломатууд, төрийн албан хаагчид, иргэний нийгмийн зүтгэлтнүүдээс гадна НҮБ-ын Нью Иорк, Женев дэх төвүүдэд ажилладаг мэргэжилтнүүдтэй ярилцлага зохион байгуулах, холбогдох хууль тогтоомж, бодлого, хөтөлбөрт дүн шинжилгээ хийх, нийгмийн үзэгдэл, арга хэмжээг ажиглах, холбогдох онолыг судлах.<br>○ Австралийн Үндэсний Их Сургуулийн Нийгмийн Зохицуулалт, Дэлхийн засаглалын сургууль, Хууль зүйн коллеж, Монголын Хүрээлэнгийн эрдэм шинжилгээний бусад ажилд оролцох, бакалавр, мастерын оюутнуудад семинар, лекц хийх.<br><br>• 2011 оны 1 сараас 2012 оны 1 сар. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын **Ажлын албаны дарга**<br><br>○ ХЭҮК-ийн ажлыг албыг удирдан зохион байгуулах, Комиссын стратегийн, жилийн, улирлын сарын төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах.<br>○ Төрийн албаны тухай хууль, Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хуулийн хүрээнд Комиссын хүний нөөц, санхүү, аж ахуйн ажлуудыг зохион байгуулах, дотоод дүрэм журмыг боловсруулах, ажилтнуудыг чадавхижуулах.<br>○ Хууль тогтоомж, бодлогын төсөлд санал өгөх, хүний эрхийн судалгаа, хяналт шалгалт явуулах, хүний эрх, эрх чөлөөний илтгэл боловсруулахад биечлэн оролцох.<br>○ Комиссын гадаад, дотоод хамтын ажиллагааг хөгжүүлэх.<br><br>• 2007 оны 3 сараас 2011 оны 1 сар. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын **бодлого, дүн шинжилгээ хариуцсан ахлах референт**<br><br>○ Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээ, хууль тогтоомжид заасан хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтэд хяналт тавих, судалгаа, дүн шинжилгээ хийх, хяналт шалгалт явуулах<br>○ Хууль тогтоомж, бодлогын төсөлд өгөх санал боловсруулах, хүний эрх, эрх чөлөөний илтгэл боловсруулахад оролцох. |

| | | |
|---|---|---|
| | | ○ Мэргэшсэн асуудлуудаар хүний эрхийн сургалт явуулах.<br><br>• 2004 оны 2 сараас 2007 оны 3 сар. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комисст **бодлого дүн шинжилгээ хариуцсан референт**<br><br>○ Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээ, хууль тогтоомжид заасан хүний эрх, эрх чөлөөний хэрэгжилтэд хяналт тавих, судалгаа, дүн шинжилгээ хийх, хяналт шалгалт явуулах<br>○ Хууль тогтоомж, бодлогын төсөлд өгөх санал боловсруулах, хүний эрх, эрх чөлөөний илтгэл боловсруулахад оролцох.<br>○ Мэргэшсэн асуудлуудаар хүний эрхийн сургалт явуулах.<br><br>• 2003.09 – 2004.02 Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Газрын тосны хэрэг эрхлэх газарт **олон улсын гэрээ, хэлэлцээр хариуцсан мэргэжилтэн**<br><br>○ Монгол Улсын Засгийн газраас БНХАУ-ын аж ахуйн нэгжтэй газрын тосны бүтээгдэхүүн хуваах гэрээ байгуулах хэлэлцээ явуулахад оролцох, холбогдох баримт бичгийг боловсруулах, бэлтгэх.<br>○ Шаардлагатай тохиолдолд хятад, англи, монгол хэлний аман болон бичгийн орчуулга хийх. |
| 8 | **Ёс зүй**<br>Доор дурсан асуудлыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дараалаар бичиж, түүний гол агуулгыг тодорхойлно.<br>-сахилгын шийтгэлээр ажлаас халагдаж байсан эсэх;<br>-сүүлийн таван жилд улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байсан эсэх. | • Сахилгын шийтгэлээр ажлаас халагдаж байгаагүй.<br>• Ял шийтгүүлж байгаагүй.<br>• Сүүлийн таван жилд улс төрийн албан тушаал болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байгаагүй. |
| 9 | **Хууль зүйн өндөр мэдлэг, чадвар**<br>Хүсэлт гаргагчийг хууль зүйн өндөр мэдлэг, чадвартай гэдгийг нотлон харуулах хамгийн чухал 10 мэргэжлийн үйл ажиллагааг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дараалаар бичиж, тодорхойлно. Үүнд дараах мэдээллийг бичнэ.<br>-үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа;<br>-үйл ажиллагааны гол агуулга;<br>-үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ;<br>-үйл ажиллагааг удирдсан албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл; | ○ 2012 – 2017 онд “Transcending Human Rights Instrumentalism” (“Хүний эрхийн гэрээний хуульжсан дэглэмийг эргэцүүлэх нь”) сэдвээр олон улсын хүний эрхийн гэрээний улс орнуудын эрхзүй, нийгэм, улс төрд үзүүлж буй нөлөөллийн мөн чанарыг шинжилсэн онолын судалгаа хийж, Австралийн Үндэсний Их Сургуульд докторын зэрэг хамгаалсан. Судалгааг Мельбурний Их Сургуулийн профессор Hilary Charlesworth удирдаж, зөвлөхөөр Нью Сауд Вэйлсийн Их Сургуулийн профессор Andrew Byrnes, Флиндерс Их Сургуулийн лектор, доктор Benjamin Authers нар ажилласан. Судалгааг ХБНГУ-ын Protestant University of Applied Studies-ийн профессор, НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хорооны дарга Theresia Degener, Английн Edinburgh Napier University --ийн профессор Jill Stavert, Австралийн RMIT University-ийн профессор Penelope Weller нар шүүсэн. Судалгаа Австралийн Үндэсний Их Сургуулийн судалгааны санд олон нийтэд нээлттэй тавигдсан бөгөөд 2020 оны 5 сарын байдлаар уг ажил АНУ, Австрали, |

| | | |
|---|---|---|
| | -хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан туваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл;<br>-хэвлэгдсэн бол эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар. | Англи, Франц, Япон, Малайз, Герман, Өмнөд Солонгос, Вьетнам, Монгол зэрэг улсуудаас 219 удаа татагдаж, 184 удаа онлайн хэлбэрээр уншигджээ. Судалгааны ажилд үндэслэн эрдэм шинжилгээний өгүүлэл, нэг сэдэвт бүтээлийн төсөл боловсруулж байна.<br><br>○ 2010 – 2018 онд Шведийн Лундын Их Сургуулийн Раул Валленбергийн хүрээлэнгийн санхүүжилтээр Ази, номхон далайн бүс нутгийн улс орнуудын хүний эрхийн үндэсний байгууллагуудын бүрэн эрх, үйл ажиллагааны талаарх судалгааны ажилд оролцсон. Судалгааны ажлыг Австралийн Хүний Эрхийн Комиссын дарга асан, профессор Brian Burdekin-ий удирдаж, миний бие KPMG Australia зөвлөх үйлчилгээний фирмийн хүний эрх, нийгмийн нөлөөллийн асуудал хариуцсан захирал, доктор Megan Brodie-той хамтран ажилласан. Ажлын үр дүн профессор Brian Burdekin-ний 2006 онд хэвлэгдсэн “National Human Rights Institutions in the Asia-Pacific Region” номын хоёрдугаар боть болж хэвлэгдэнэ. Уг номонд Афганистан, Зүүн Тимор, Иордан, Палестин, Катар, Самоа зэрэг улсуудын хүний эрхийн үндэсний байгууллагуудын бүрэн эрх, үйл ажиллагааг харьцуулан дүгнэх, НҮБ ба хүний эрхийн үндэсний байгууллагуудын хамтын ажиллагаа 1990-2016 онд хэрхэн хөгжсөнийг зураглахын тулд НҮБ-ын Хүний эрхийн зөвлөл, тусгай илтгэгчид, гэрээний хороодын 500 орчим баримт бичгийг шинжлэх ажлыг дангаараа гүйцэтгэсэн. Судалгааны үр дүнг Brill хэвлэлийн газарт шилжүүлсэн.<br><br>○ Харвардын хуулийн сургууль, Хүний эрх, хүмүүнлэгийн эрх зүйн Женевийн Академи, Лундын их сургуулийн Раул Валленбергийн хүрээлэн зэрэг дэлхийд нэр хүндтэй эрдэм шинжилгээний байгууллагад хүний эрх, олон улсын эрх зүй, үндсэн хуулийн эрх зүйн асуудлаар сургалтад хамрагдаж, мэргэжил дээшлүүлсэн. Сургалтын гэрчилгээнүүдийг хавсаргав.<br><br>○ ХБНГУ-ын Фрайбург хотод төвтэй Particip GmBH олон улсын зөвлөх үйлчилгээний фирмд хүний эрхийн шинжээчээр ажиллаж, Европын Комисст бодлогын зөвлөгөө, туслалцаа үзүүлж байна. 5, 7 дугаар хэсэгт өгсөн мэдээллийг үзнэ үү. Гэрээний нөхцлөөс хамаарч 2019 оны 11 сард хийсэн мониторингийн тайланг бүхэлд нь хавсаргах боломжгүй боловч тайлангийн агуулга, дүгнэлт, зөвлөмжийн хамт хавсаргалаа.<br><br>○ Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссоос УИХ-д өргөн барьдаг хүний эрх, эрх чөлөөний 2006, 2007 оны илтгэлийн ерөнхий редактороор ажилласан. Илтгэлүүдтэй www.nhrcm.gov.mn хуудаснаас танилцаж болно.<br><br>○ 2004-2010 онд Хүний эрхийн Үндэсний Комисст ажиллахдаа сонгох, сонгогдох эрх, эвлэлдэн нэгдэх эрх, тайван жагсаал цуглаан зохион байгуулах эрх, хүний эрхийн боловсрол, хууль зүйн туслалцаа авах эрх, хүүхдийн эрх, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаан дахь хүний эрх, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрх, хөдөлмөрлөх эрх, БНСУ-д ажиллаж буй Монгол иргэдийн эрхийн асуудлаар судалгаа хийж, хорих анги, |

| | | |
|---|---|---|
| | | цагдан хорих төвүүд, хүүхдийн асрамжийн газрууд, сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв, цэргийн анги нэгтгэлүүдэд хүний эрхийн шалгалтууд явуулж, тайлан боловсруулсан. Эдгээр ажлуудын үр дүн 2005 – 2011 оны хүний эрх, эрх чөлөөний илтгэлүүдэд тусгагдсан. |
| 10 | **Хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах чиглэлээр эрхэлсэн ажил**<br>Хүсэлт гарагч хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалах чиглэлээр сүүлийн таваас доошгүй жил эрхэлсэн ажлыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн он дараалаар бичиж, тодорхойлно. Үүнд дараах мэдээллийг бичнэ:<br>-албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа;<br>-ажлын байрны тодорхойлолт;<br>-удирдах албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл;<br>-хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан таваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл. | • 2004 оны 2 дугаар сараас хойш тасралтгүй Монгол Улсад болон олон улсын төвшинд хүний эрхийн салбарт ажилласан. 7 дугаар хэсэгт бичсэн мэдээллийг бүхэлд нь үзнэ үү.<br>• Мөн эрх зүйч мэргэжил эзэмшихээсээ өмнө буюу МУИС-ын Хууль зүйн сургуульд оюутан байх үеэсээ хүний эрхийн салбарт ажиллаж эхэлсэн. Тухайбал:<br>o 2002 оны 3 сараас 6 сарыг хүртэл Монголын Эмнести Интернэшнл байгууллагад Олон Улсын Эрүүгийн Шүүхийн Ромыг дүрмийг соёрхон батлуулахын төлөөх кампанит ажлын зохицуулагч цалинтай дадлагажигч<br>o 2002 оны 9 сараас 2003 оны 3 дугаар сарыг хүртэл Либерал Эмэгтэйчүүдийн Оюуны Сан ТББ-ын Хүний эрх, ардчилал хөтөлбөрийн зохицуулагчаар (үндсэн ажилтан) ажилласан. |
| 11 | **Хүний эрхийг хүндэлж, дээдэлдэг байдал**<br>Хүсэлт гаргагчийн хүний эрхийн мэдлэг, чадвар, хүний эрхийг хүндэтгэж, дээдэлдэг гэдгийг нотлон харуулах хамгийн чухал 10 үйл ажиллагааг сүүлийнхээс нь эхлэн он дараалаар бичиж, тодорхойлно. Үүнд дараах мэдээллийг бичнэ:<br>-үйл ажиллагааны нэр, эрхэлсэн газар, хугацаа;<br>-үйл ажиллагааны гол агуулга;<br>-үйл ажиллагааны үр дүн, түүний жишээ;<br>-үйл ажиллагааг удирдсан албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл;<br>-хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан таваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл;<br>-хэвлэгдсэн бол эх сурвалжийн ишлэл, түүний хуулбар. | • 5, 7, 9, 10, 14 дүгээр хэсгийн хариултыг үзнэ үү. |
| 12 | **Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх** | Хамааралгүй. |

| | | |
|---|---|---|
| | **ажиллагааны туршлагын талаар**<br>Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний албан тушаалд нэр дэвших тухай хүсэлт гаргагч нь эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд мөрдөгч, өмгөөлөгч, прокурор, шүүгчээр ажиллаж байсан бол тэдгээрийн сүүлийнхээс нь эхлэн он дараалаар бичиж, тодорхойлно. Үүнд дараах мэдээллийг бичнэ:<br>-албан тушаалын нэр, ажлын газрын хаяг, ажилласан хугацаа;<br>-ажлын байрны тодорхойлолт;<br>-удирдах албан тушаалтны нэр, холбоо барих мэдээлэл;<br>-хамтран ажиллаж байсан болон өөрийн удирдлагад ажиллаж байсан таваас доошгүй хүний нэр, холбоо барих мэдээлэл<br>**Жич: Энэ зүйл нь Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүнд нэр дэвших тухай хүсэлт гаргагчид хамаарахгүй.** | |
| **13** | **Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүнчлэлийн талаар**<br>Монголын Хуульчдын холбоо, Монголын Өмгөөлөгчдийн холбоо, хууль зүйн эсхүл хүний эрхийн бусад холбоо, байгууллагад гишүүн бол нэрлэн бичнэ.<br>-Мэргэжлийн холбоо, байгууллагын гишүүн болсон огноог бичнэ. Уг байгууллагын гишүүнчлэлийг түдгэлзүүлж, хүчингүй болгож, дуусгавар болгож байсан бол энэ талаар бичиж, шалтгааныг нь тайлбарлана.<br>-Мэргэжлийн холбоо, байгууллагад эрхэлж байсан албан тушаалын нэр, огноог бичнэ. | • Австрали, Шинэ Зеландын олон улсын эрх зүйн нийгэмлэгийн (www.anzsil.org) гишүүн.<br>• Олон улсын эрх зүйн Азийн нийгэмлэгийн (www.asiansil.org) гишүүн.<br>• Олон улсын эрх зүйч, хүний эрхийг хамгаалагч эмэгтэй хуульчдын ATLAS сүлжээний (www.atlaswomen.org) гишүүн. |
| **14** | **Хэвлүүлсэн бүтээл болон олон нийтэд өгсөн мэдээлэл**<br>-Өөрийн боловсруулсан, хянасан ном, өгүүлэл, тайлан, шийдвэр, зөвлөмж зэрэг аливаа хэлбэрээр хэвлүүлсэн материал байгаа бол гарчиг, хэвлэсэн газар, огноог бичнэ.<br>-Өөрийн харьяалагддаг байгууллагын | Англи хэл дээр хэвлүүлсэн, хэлэлцүүлсэн бүтээлүүдийг англи хэл дээр бичиж, сэдвийн орчуулгыг хашилтанд оруулсан болно.<br><br>**Нэг. Нэг сэдэвт бүтээл, гарын авлага**<br><br>1. Transcending Human Rights Instrumentalism (Хүний эрхийн гэрээний хуульжсан дэглэмийг эргэцүүлэхүй), (олон улсын эрх зүй, засаглалын асуудлаар докторын зэрэг горилсон |

| | | |
|---|---|---|
| | нэрийн өмнөөс бэлдсэн, эсхүл бэлдэхэд оролцсон аливаа хууль тогтоомж, дүрэм, журам, шийдвэр, тайлан, зөвлөмж болон бусад материал байгаа бол түүнийг хэвлэсэн байгууллагын нэр, хаяг, огноо, гол агуулгыг бичнэ.<br>-лекц, илтгэл, нээлтийн үг зэрэг илтгэл, яриа, огноо болон газрыг зааж, энэ талаар олон нийтийн мэдээллийн хэрэгслээр цацагдсан бол энэ тухай бичнэ. Хэрэв таны илтгэл, ярианы хуулбарыг хийх боломжгүй бол түүнийг зохион байгуулсан байгууллагын нэр, хаяг, илтгэл, ярианы огноо, товч агуулгыг бичнэ.<br>-хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд өгсөн ярилцлагыг хамгийн сүүлийнхээс нь эхлэн жагсааж бичнэ. Ярилцлагуудын огноог зааж, боломжтой бол ярилцлагын тэмдэглэл, дүрс бичлэгээс хуулбарлан өгнө.<br><br>**Жич:** Дээр дурдсан материал тус бүр хоёр хувийг хавсаргана. | бүтээл, Австралийн Үндэсний Их Сургууль, 2017) Судалгааг дараах линкээс үзнэ үү <https://openresearch-repository.anu.edu.au/handle/1885/143570>.<br><br>2. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцийг тайлбарлах нь: Шийдвэр гаргагчдад зориулсан гарын авлага (Хүний эрхийн Үндэсний Комисс, 2008)<br><br>**Хоёр. Эрдэм шинжилгээний өгүүлэл, эссе**<br><br>1. *“Understanding a human rights change: Lessons from the UN Convention on the Rights of Persons with Disabilities in Australia and Mongolia”* (Хүний эрхийн өөрчлөлт хэрхэн явагддаг вэ? Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцийн нөлөө Австрали ба Монгол Улсуудад) (Submitted to *Australian Journal of Human Rights* in March 2020).<br><br>2. *“The nature of Mongolia’s legal protection of human rights”* (Монгол Улсын хүний эрхийн хууль зүйн хамгаалалтын мөн чанар) (Англи хэл дээрх судалгааны эссе, 2010) <https://gnarantuya.com/the-nature-of-mongolias-legal-protection-of-human-rights/>.<br><br>3. *“A questionable standing: The National Human Rights Commission of Mongolia in public interest litigation”* (Эргэлзээтэй бүрэн эрх: Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын нийтийн эрх ашгийг төлөөлж шүүхэд нэхэмжлэл гаргах эрх зүйн зохицуулалт) (Англи хэл дээрх судалгааны эссе, 2010) <https://gnarantuya.com/a-questionable-standing-the-national-human-rights-commission-of-mongolia-in-public-interest-litigation/>.<br><br>4. “The right to peaceful assembly and demonstration: Should traffic obstruction prevail?” (Тайван жагсаал цуглаан хийх эрх: Жагсагчид замын хөдөлгөөнийг саатуулах эрхтэй юу?) (Англи хэл дээрх судалгааны эссе, 2009) < https://gnarantuya.com/the-right-to-peaceful-assembly-and-demonstration-should-traffic-obstruction-prevail/>.<br><br>5. “An analysis of the quasi-judicial competence of the National Human Rights Commission of Mongolia” (Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын өргөдөл гомдол шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалт, практик) (Англи хэл дээрх судалгааны эссе, 2009) <https://gnarantuya.com/an-analysis-of-the-quasi-judicial-competence-of-the-national-human-rights-commission-of-mongolia/>.<br><br>6. “Олон улсын хүний эрхийн гэрээний хэм хэмжээг тайлбарлах асуудалд” *Хүний эрх сэтгүүл* (2007 оны 3 дахь дугаарын 72 дахь тал) Хүний эрхийн сэтгүүлүүдийг дараах линкээс үзэх боломжтой <http://nhrcm.gov.mn/мэдээ/хүний-эрх-сэтгүүлийн-бүх-дугаар/><br><br>7. “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцийн үзэл санаа, түүх” *Хүний эрх сэтгүүл* (2006 оны 4 дэх дугаарын 16 дахь тал) |

| | | |
|---|---|---|
| | | 8. Олон улсын хүний эрхийн гэрээ, конвенцийн хэрэгжилтэд тулгамдсан асуултууд, *Хүний эрх сэтгүүл* (2005 оны 4 дэх дугаарын 11 дахь тал)<br><br>**Гурав. Судалгаа**<br><br>*Энэ хэсэгт зөвхөн томоохон цар хүрээтэй судалгааны ажлуудыг жагсаалаа. Тусгай төслийн хүрээнд явуулснаас бусад Хүний эрхийн Үндэсний Комисст бодлого, дүн шинжилгээний ажил хариуцаж байхдаа хийсэн судалгаа, мониторингийн ажлуудыг жагсаалтанд тусгаагүй.*<br><br>1. *Studies of partner country progress in implementing seven core human rights conventions: Mongolia* (Хамтрагч улс орнууд хүний эрхийн үндсэн гэрээг хэрэгжүүлж буй байдалд хийсэн дүн шинжилгээ), in contract with Particip GmbH (2019).<br><br>2. *Capacity Assessment Report of the Australian Human Rights Commission* (Австралийн Хүний эрхийн Комиссын чадавхийн үнэлгээ), with Rosslyn Noonan, Chris Sidoti, Aparna Basnyat, Jungrin Kim (2012) confidential report.<br><br>3. *Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүд*, П.Оюунчимэг, Ч.Алтангэрэл нарын хамт (2008) ХЭҮК-ийн ажлын хүрээнд.<br><br>4. *БНСУ-д ажиллаж буй Монгол иргэдийн нөхцөл байдал, эрхийн хэрэгжилт*, Филантрофи хөгжлийн төлөө төв ТББ, Ж.Дашдорж нарын хамт (2007) ХЭҮК-ийн ажлын хүрээнд.<br><br>5. *Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн хэрэгжилт* (2006) ХЭҮК-ийн ажлын хүрээнд.<br><br>6. *Хүний эрхийн боловсрол ерөнхий боловсролын сургуулиудад*, Б.Хишигсайхан, Б.Батбаатар, Г.Золжаргал, А.Саруул нарын хамт (2005) ХЭҮК-ийн ажлын хүрээнд.<br><br>7. *Үйлдвэрчний эвлэлд эвлэлдэн нэгдэх эрх чөлөө болон байгууллага байгуулах эрхийн тухай Олон Улсын Хөдөлмөрийн байгууллагын 87, 98 дугаар конвенциудын хэрэгжилт Монгол Улсад,* Монголын Үйлдвэрчний эвлэлийн холбоо, Г.Далайжамц нарын хамт (2004) ХЭҮК-ийн ажлын хүрээнд.<br><br>**Дөрөв. Эрдэм шинжилгээний хуралд хэлэлцүүлсэн илтгэл**<br><br>*Зөвхөн олон улсын эрдэм шинжилгээний хуралд тавьсан илтгэлүүдийг оруулсан. Олон нийтийн лекц, хэлэлцүүлэгт яриа хийсэн, сургалтад хичээл заасан байдлыг тооцоолох боломжгүй.* |

| | | |
|---|---|---|
| | | 1. *"What role an institutional agent can play in social change? In the case of the Mongolian Human Rights Commission"* (Нийгмийн өөрчлөлтөд байгууллага ямар үүрэг гүйцэтгэж байна вэ? Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын жишээнд дээр) (presented at 'Women in Political Leadership' symposium, Griffith University, Brisbane, Australia 27-28 November 2017).<br><br>2. "*Mongolia's Commitment to International Human Rights Law and Social Change"* (Монгол Улсын олон улсын хүний эрхийн эрх зүйг хэрэгжүүлж буй байдал ба нийгмийн өөрчлөлт) (Paper presented at the Third Open Conference on Mongolian Studies, ANU Mongolia Institute, Australian National University, 03 November 2015).<br><br>3. *"A Regulatory Approach to Human Rights"* (Хүний эрхийн асуудалд нийгмийн зохицуулалтын онолын үүднээс хандах нь) (Paper presented at Future of Human Rights Conference, Centre for International Governance and Justice, School of Regulation and Global Governance, Australian National University, 26 October 2015).<br><br>4. *"Implementation of the UN Convention on the Rights of Persons with Disabilities in Mongolia"* (Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай НҮБ-ын конвенцийн хэрэгжилт Монгол Улсад) (Paper presented at Biannual Conference of Canadian Law and Society Association and Law and Society Association of the Australia and New Zealand, University of British Columbia, 4 July 2013).<br><br>5. *"National Inquiry on Torture: Reflections and Lessons from the Mongolian Human Rights Commission"* (Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссоос явуулсан эрүү шүүлтийн нээлттэй хяналт шалгалтын сургамж) (Paper presented at Human Rights Promotion in Development Cooperation-Good Practice seminar, Lund University, 18 June 2010).<br><br>6. *"Rethinking Quasi-Judicial Competence of the National Human Rights Commission of Mongolia"* (Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын өргөдөл гомдол шийдвэрлэх ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг сайжруулах асуудалд) (Paper presented at 'Creating Change? NHRIs (In)Action in the Asia Pacific Region Conference, Institute for International Law and the Humanities, Melbourne Law School, 2002 July 2009).<br><br>**Тав. Олон нийтэд зориулсан нийтлэл**<br><br>2019 оны 6 дугаар сараас эхлэн Монгол Улсын нийгэм, улс төр, эрх зүйн асуудлаар бичсэн нийтлэлээ www.jargaldefacto.com болон өөрийн ww.gnarantuya.com цахим хуудсуудаар түгээж байна.<br><br>Эдийн засагч Д.Жаргалсайхны санаачилсан www.jargaldefacto.com платформд дараах нийтлэлүүдийг байршуулсан нь 2020 оны 5 сарын байдлаар нийт дүнгээр 38056 удаа |

| | | |
|---|---|---|
| | | уншигджээ. Нийтлэлүүдийг http://jargaldefacto.com/profile/narantuya.g профайлаар орж үзнэ үү.<br><br>1. Хүний эрхийн үндэсний комиссоо чангаруулах уу?<br>2. Хүний эрх – хууль зүйн ойлголт<br>3. Ерөнхийлөгчийн засаглалыг эсэргүүцэхийн учир (Нэгдүгээр хэсэг)<br>4. Ерөнхийлөгчийн засаглалыг эсэргүүцэхийн учир (Хоёрдугаар хэсэг)<br><br>Өөрийн www.gnarantuya.com цахим хуудсанд дараах нийтлэл, үзэл бодлыг байршуулсан нь 2020 оны 5 сарын байдлаар нийт дүнгээр 18701 удаа уншигджээ. Нийтлэлүүдийг https://gnarantuya.com/blog/ линкээр орж үзнэ үү.<br><br>1. Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд өгөх санал<br>2. Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт өөрчлөлтийн “Шүүх эрх мэдлийн хариуцлагыг дээшлүүлэх, хараат бус байдлыг хангах тухай” хэлэлцүүлэгт гаргасан санал<br>3. Тоталитар төрийн үүсэл<br>4. Хуульчид хоосон цэцэрхээгүй: Судлаач Ганаа ахад<br>5. Жоомоо алах гээд байшингаа шатаав |

--- oOo ---